

Суралцахуйн үр дүнд суурилсан боловсролын чанарын баталгаажуулалтын тогтолцоо

Ж. Тунгалаг¹

Үндэслэл

Шинжлэх ухаан, технологийн хөгжил хурдсахын хирээр ажил мэргэжил, түүнд шаардагдах ур чадваруудын хэрэгцээ хувьсан өөрчлөгдөж урьдчилан таамаглах аргагүй болж байна. Ажил олгогч, дээд боловсролын сургалтын байгууллага, төгсөгчдийн аль алинд энэ асуудал бэрхшээл учруулж, хамтын шийдэлд хүрэх арга замуудыг хайж байна. Өөрчлөгдөн буй хэрэгцээ шаардлагад илүү уян хатан зохицох, тухайн ажил мэргэжилд шаардагдах ур чадварыг бие даан үр дүнтэй хөгжүүлэх ерөнхий ур чадваруудыг эзэмшүүлэх нь боловсролын үндсэн зорилго төдийгүй хувь хүний, нийгэм эдийн засгийн хөгжлийн гол хандлага боллоо. Боловсролын чанар нь эдгээр ур чадваруудыг хэрхэн урьдчилан тодорхойлж, төлөвлөн хэрэгжүүлж, үнэлж, сайжруулж байгаагаар хэмжигдэх болов. Сургалтын агуулга, сурлагын амжилтаар боловсролын чанарыг үнэлдэг уламжлалт тогтолцооноос суралцахуйн үр дүнг баталгаажуулдаг тогтолцоо руу шилжихэд хөтөлбөрийн урьдчилсан магадлан итгэмжлэл чухал үүрэгтэй төдийгүй боловсролын чанарын шинэчлэлд олон нийтийн оролцоо, боловсролын үнэ цэнийг нэмэгдүүлэх нөхцлийг бүрдүүлэх боломжтой нь зарим жишээгээр харагдаж байна. Хөтөлбөрийн урьдчилсан магадлан итгэмжлэл хийхэд тулгарч байгаа асуудлуудыг тогтоон, шийдвэрлэх арга замыг тодорхойлох нь хэрэгжиж байгаа хөтөлбөрийн, түүнчлэн байгууллагын магадлан итгэмжлэлийг харилцан уялдаатай, үр дүнтэй хэрэгжүүлж, Монгол улсын дээд боловсролын чанарын баталгаажууллын үндэсний тогтолцоог хөгжүүлэхэд түлхэц болох юм.

Түлхүүр үгс: суралцахуйн үр дүн, урьдчилсан магадлан итгэмжлэл, хөтөлбөрийн магадлан итгэмжлэл, чанарын баталгаажуулалтын тогтолцоо

¹ Боловсролын Магадлан Итгэмжлэх Үндэсний Зөвлөл (БМИҮЗ)
E-mail: tungalag@accmon.mn

Дээд боловсролын олон улсын
чиг хандлага

Оюутан, суралцагсдын төдийгүй, мэргэжил эзэмшсэн хүмүүс, түүнчлэн өндөр ур чадвартай ажиллах хүчний хил дамнасан шилжилт хөдөлгөөн дэлхийн бүх улс, бүс нутагт нэмэгдэж байгаатай холбоотойгоор “хил дамнасан боловсрол”, түүний чанарын баталгаажуулалтын талаар ЮНЕСКО-гоос 2005 онд зөвлөмж гаргасан юм (OECD & UNESCO, 2005). Олон улсын боловсролын чанарыг сайжруулах, түүнчлэн ил тод, бодит байдлаар чанарыг харилцан хүлээн зөвшөөрөх механизмыг дэмжин хөгжүүлэхийн хамт оюутан суралцагчид, бусад холбогдох талуудыг чанаргүй боловсролоос хамгаалах нь энэ зөвлөмжийн гол зорилго бөгөөд үүнийг хэрхэн хэрэгжүүлэхийг улс орнуудын төр засаг, дээд боловсролын сургалтын байгууллага (ДБСБ), оюутны байгууллага, чанарын баталгаажуулалтын болон магадлан итгэмжлэлийн байгууллага, эрдмийн болон мэргэжлийн байгууллагуудад зөвлөсөн.

Энэхүү зөвлөмжийг Organisation for Economic Co-operation and Development (OECD)-ийн гишүүн ба гишүүн бус орнуудад хэрэгжүүлж байгаа тухай өргөн хүрээний судалгааны тайланг 2012 онд OECD (Vincent-Lancrin & Protenhauer, 2012) гаргасан. Зөвлөмжийн утга агуулга, ач холбогдол нь цаашид хэвээр үргэлжлэхийг уг тайланд онцлон тэмдэглээд ДБСБ болон чанарын баталгаажуулалтын байгууллага хамтран мэдлэг, чадварыг ил тод, бодит үнэлэх боловсролын “стандарт”-ыг тогтоосон үндэсний тогтолцоог хөгжүүлэх нэг арга зам нь 1980-аад оноос Их Британи болон бусад англи хэлтэй улс орнуудад хөгжиж байсан Мэргэшлийн үндэсний хүрээ бөгөөд энэ нь албан ба албан бус

(насан туршийн) боловсролыг үнэлэх боломж юм гэж заасан.

Үндэсний боловсролын тогтолцооны шинэчлэлийн хүрээнд дотоод, гадаад чанарын баталгаажуулалтын тогтолцоог бүрдүүлэх, улмаар энэхүү тогтолцоог дэмжсэн Мэргэшлийн үндэсний хүрээ (МҮХ)-г бий болгон, хэрэгжүүлэх нь үндсэндээ 1980-аад оноосхойш бий болсон олон улсын томоохон чиг хандлагын нэг юм. Анхны санаачлага Англи хэл бүхий өндөр хөгжилтэй оронд гарч, цааш нь мөн л Англи хэлтэй, өндөр хөгжилтэй орнуудад түгэн дэлгэрсэн байдаг. Гэхдээ, 1990-ээд оны сүүлээс албан ёсны Англи хэлгүй, хөгжиж буй орнууд ч МҮХ-г боловсруулан, хэрэгжүүлж эхэлсэн (Судирман & Цагаач, 2016).

МҮХ-г хөгжүүлэх нь мэргэжлийн диплом, эрдмийн зэргийг харилцан хүлээн зөвшөөрөхөд тус дөхөм болохын зэрэгцээ суралцагч, төгсөгч, мэргэжилтний мэдлэг, чадамжийг үнэлэх, баталгаажуулах, хүлээн зөвшөөрүүлэх үндсэн суурь нь юм. Улс орнууд өөрийн МҮХ-г олон талын оролцоотойгоор ялангуяа эдийн засаг, бизнесийн салбарын ажил олгогчдын эрэлт хэрэгцээ, нийгэм, соёлын болон хувь хүний эрэлт хэрэгцээнд нийцүүлэн боловсруулж, хөгжүүлж байгаа нь дээд боловсролын үнэ цэнэ, үр нөлөөг нэмэгдүүлж байна. Европын холбооны гишүүн орнууд МҮХ-гээ бусад улс орнуудтай харьцуулах, хөтөлбөрийн төдийгүй нэгж судлагдахууны түвшинд суралцахуйн үр дүнг харилцан жишихүйцээр боловсруулах зорилгоор 2000 оноос Tuning Project (www.unideusto.org/tuningeu) хэрэгжүүлснээр Европын дээд боловсролын мэргэшлийн хүрээг (Bologna, 2005) хөгжүүлж, улмаар суралцахуйн үр дүнг хэмжих, үнэлэх, баталгаажуулах ECTS (EC, 2012)

тогтолцоог бүрдүүлсэн.

Болонийн үйл явцын туршлагаас харахад хөтөлбөрийн суралцахуйн үр дүнг МҮХ нийцүүлэн холбогдох салбар мэргэжлийн болон сургуулийнхаа нийтлэгийг харгалзан тодорхойлж, харилцан уялдаатайгаар хөгжүүлж байна.

Монгол улсын дээд боловсролын чиг хандлага

1990 оноос хойш Монгол улсын дээд боловсролын хөгжлийн байдлыг тоймлон авч үзвэл олон улсын чиг хандлагын дагуу тооны өсөлтөөс агуулга, агуулгаас чанар, чанарын сайжруулалтаас баталгаажуулалт руу чиглэн хөгжиж ирлээ. 1995 онд батлагдсан Боловсролын тухай багц хуулиар боловсролыг “тэргүүлэх салбар болгон хөгжүүлэх, төрийн ивээл, зохицуулалт, төр, олон нийтийн хяналтанд байлгана” гэж заасан ба дээд боловсролын агуулгыг бакалавр, магистр, докторын шатлал бүхий кредит цагт суурилсан зохион байгуулалтанд шилжүүлж, “Боловсролын агуулгыг хуулиар тодорхойлж, стандартаар нарийвчлан тогтооно. Боловсролын стандарт нь суралцагчид зайлшгүй эзэмшсэн байх агуулга, түүний үнэлгээ, багшийн мэргэжлийн түвшин, сургалтын байгууллагад тавигдах үндсэн шаардлагыг тодорхойлно” хэмээн тусгасан. Эдгээр нь тухайн үеийн дэлхий нийтийн боловсролын хөгжлийн чиг хандлага, ялангуяа Болонийн үйл явцад нийцсэн шинэчлэл байлаа.

1998 оны Боловсролын хуулийн нэмэлт өөрчлөлтөнд боловсролын зорилгыг “иргэнд эрүүл чийрэг бие бялдар, оюуны зохих чадавхитай, хуулийг дээдлэн сахидаг, хүмүүнлэг, ёс суртахуун, гоо зүйн мэдрэмж, таашаал олж, бие даан сурч,

амьдрах чадвартай болоход нь үйлчлэх” гэж тодорхойлсон юм (Бат-Эрдэнэ, 2012). Мөн ЗГ-ын хөтөлбөрт “Сургалтын агуулга, арга зүйг академик шинжээс онол, практик хосолсон сургалтын шинэ шинж, төлөвт шилжүүлж, шавь төвтэй сургалтыг дэмжинэ” гэж дэлгэрүүлэн оруулжээ. Үүний дагуу Гэгээрлийн сайдын 1998 оны 255 дугаар тушаалаар “Дээд боловсролын зэрэг олгох сургалтанд кредит цагийг хэрэглэх, суралцагчдын мэдлэг, чадварыг дүгнэх журам”-ыг баталж их дээд сургуулиуд хэрэглэж эхэлсэн нь ДБСБ-уудын үйл ажиллагаанд хийгдсэн том шинэчлэл болжээ. Ингэснээр сургалтыг блок байдлаар, хэсэгчилсэн, мөн оюутны бие даан ажиллах ба танхимын хичээлийг нарийвчлан тооцсон америк стандартанд нийцсэн сургалтын систем руу шилжүүлж эхэлжээ (Батчимэг & Тамир, 2013). Үүнээс үзэхэд суралцахуйн үр дүнд суурилсан, суралцагч төвтэй боловсролын үзэл баримтлалыг 1998 оноос хэрэгжүүлж эхэлсэн байна.

Дээд боловсролын хуулийн нэмэлт өөрчлөлтөнд “яам бүх шатны боловсролын стандарт, норм, норматив боловсруулах, дээд боловсролын мэргэжлийн чиглэлийг тогтооно” гэж заасны дагуу 2002 онд БСШУЯ-наас “Бакалаврын боловсролын стандартын үлгэрчилсэн загвар”-ыг баталж, улмаар 2006 онд уг загварт өөрчлөлт оруулсан байдаг. Үүний дагуу 2003-2013 онд 130 мэргэжлээр дээд боловсролын стандартыг баталж мөрдсөн байна. Эдгээр стандартуудад төгсөгчдийн эзэмшсэн байвал зохих мэдлэг, чадвар, хандлагыг тодорхойлсон нь өнөөдрийн “суралцахуйн хүрээ”, “суралцахуйн үр дүн” гэдэг ойлголт юм.

Энэхүү стандартын дагуу боловсруулсан сургалтын төлөвлөгөөний дагуу сургалтыг

зохион байгуулах нь чанарыг хангах давуу талыг бий болгосон ч нийгмийн болон хувь хүний эрэлт хэрэгцээг хангах илүү уян хатан тогтолцоог бий болгох, нөгөө талаас боловсрол олгох хөтөлбөр хэрэгжүүлэх зорилгоор 2014 онд БСШУЯ-наас “Бакалаврын хөтөлбөрт тавих нийтлэг шаардлага”, “Магистр, докторын хөтөлбөрт тавих нийтлэг шаардлага”-ыг баталсан. ДБСБ-ууд академик байдлынхаа хүрээнд төгсөгчдийн ур чадвар, хичээлийн агуулгыг хүрэх үр дүнгээр тодорхойлж хөтөлбөрөө дээрх нийтлэг шаардлагуудын дагуу боловсруулан баталгаажуулж, хэрэгжүүлж эхэлсэн нь сургалтын чанарыг үнэлэх, сайжруулах, баталгаажуулах үйл явцыг мөн өөрчлөн шинэчлэхэд хүргэлээ.

Дээд боловсролын чанарын баталгаажуулалт

Дээд боловсролын шинэчлэлийн хүрээнд чанарын хяналтын олон хэлбэр бий болсны дотор ДБСБ болон хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийг хэрэгжүүлэх чиг үүрэгтэй Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөл (БМИУЗ) 1998 онд Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага санаачлан байгуулж, олон нийтийн оролцоотой хөндлөнгийн чанарын баталгаажууллын үйл ажиллагаа явуулдаг АНУ-ын туршлагад тулгуурлан өөрийн орлогоор санхүүждэг, ашгийн бус байгууллага хэлбэрээр ажиллах эрх зүйн орчныг бүрдүүлсэн.

БМИУЗ нь 2004 оноос хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийг сайн дурын үндсэн дээр хэрэгжүүлж эхлэхдээ дээр дурьдсан дээд боловсролын стандартуудад суурилсан байна. 2003-2004 онд стандарт нь батлагдсан мэргэжлүүдээр хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийг анх эхлүүлж,

Мэргэжлийн зөвлөлүүд байгуулагдсан ба түүнээс хойш ч энэ хандлага нь тууштай хэрэгжсэн байдлаас харахад мэдлэг, ур чадвар, хандлагыг хөндлөнгийн шалгуурт тодорхой хэмжээгээр тусган хэрэгжүүлж эхэлсэн байна. Гэвч энэхүү мэдлэг, ур чадвар, хандлагыг гэхээсээ илүүтэйгээр агуулгын хэрэгжилт, багшийн үйл ажиллагаа, сургалтын орчин, оюутанд чиглэсэн үйлчилгээ зэрэгт голлон үнэлгээ хийж байсан нь өөрийн үнэлгээний болон шинжээчийн тайлангуудаас харагддаг. Түүнчлэн хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийг тухайн үед ДБСБ-ууд хөтөлбөрөө сайжруулах механизм гэхээсээ илүүтэй тэнхим, профессорын багийн үйл ажиллагааны үзүүлэлт гэж үзсэн учраас зарим талаар дээрх тайлангууд нь хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгжийн үйл ажиллагаанд хийсэн дүн шинжилгээ мэт байх нь ажиглагддаг.

2010 онд БМИУЗ нь хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн шалгуур, шаардлагыг шинэчлэхдээ хөтөлбөрийн зорилго, зорилтууд ба үр дүнг чухалчилж, түүнийг хэрэгжүүлэх хичээлийн хөтөлбөрүүдэд хувь хүний хөгжил, төлөвшил, нийгэмшлийн асуудлыг тусган тасралтгүй сайжруулах ба хөтөлбөрийн хэрэгжилтийн бүхий л шатанд дотоод ба гадаад оролцогч талуудыг татан оролцуулдаг байх шаардлага тавьсан. Мөн хөндлөнгийн үнэлгээ хийх шинжээчдийн багт, шийдвэр гаргах Мэргэжлийн зөвлөлүүдэд ажил олгогчдын төлөөллийг татан оролцуулсан нь хөтөлбөрийг эрэлт хэрэгцээнд тулгуурлан сайжруулах алхам болсон юм. Гэвч өөрийн үнэлгээ ба хөндлөнгийн үнэлгээний тайлангуудаас харахад шалгуурыг хангаж буйг илтгэх нотлох баримтууд хангалтгүй байх, зарим тохиолдолд хангалттай их материал байвч

шалгуурт тохирохгүй байх нь ажиглагддаг.

2016 онд хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн шалгуурыг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэхдээ суралцахуйн үр дүнг тодорхойлох, хэрэгжүүлэх, үнэлэх, сайжруулах чанарын менежментийн тогтолцоог төлөвшүүлэхэд чиглэн үүний зэрэгцээ хөтөлбөрийн урьдчилсан магадлан итгэмжлэлийг хэрэгжүүлж эхлэв. Үнэлгээний аргачлал, шийдвэр гаргах зарчим нь үйл ажиллагааны үр дүнг баталгаажуулахад чиглэж, шинжээчдийн багт оюутны төлөөллийг оруулах болсон нь олон улсын жишигт нийцсэн шинэчлэл болов.

Монгол улсад дээд боловсролын магадлан итгэмжлэл хэрэгжиж ирсэн түүхэн хөгжлийг шалгуур үзүүлэлт, үнэлгээний арга барилын хувьд авч үзвэл 3 ангилж болохоор байна. Тухайлбал: 1998-2003 онд ДБСБ-ын анхны магадлан итгэмжлэлийг оролтод суурилсан, 2003-2013 онд хоёр дахь магадлан итгэмжлэлийг үйл явцад суурилсан, 2016 оноос үр дүнд суурилсан үнэлгээний арга барилаар хэрэгжүүлж байна. Ялангуяа хөтөлбөрийн болон урьдчилсан магадлан итгэмжлэлийн шалгуурт хөтөлбөрийн үнэлгээ, чанарын баталгаажуулалтыг шинээр оруулсан нь үр дүнд суурилсан чанарын дотоод ба хөндлөнгийн баталгаажууллын тогтолцоог бүрдүүлэх эхлэл боллоо.

Суралцахуйн үр дүнд суурилсан чанарын
баталгаажууллын тогтолцоо

Хөндлөнгийн чанарын баталгаажуулалт хөтөлбөрийн хувьд 2 хэлбэрээр хийгдэж байна. Үүнд:

- Урьдчилсан магадлан итгэмжлэл (заавал),
- Хөтөлбөрийн магадлан итгэмжлэл (сайн дурын).

Хөтөлбөрийн зорилтыг суралцахуйн хүрэх үр дүнгээр тодорхойлж, түүнийг амжилттай хэрэгжүүлэхэд чиглэсэн агуулга, түүнд тохирсон багшлахуй болон суралцахуйн арга барил, орчин, нөөц, үнэлгээний болон чанарын баталгаажуулалтын арга барилтай байх нь магадлан итгэмжлэгдэх үндсэн шалгуур юм. Тэгэхээр гол түлхүүр нь суралцахуйн үр дүн мөн боловч түүнийг хэрхэн тодорхойлох нь асуудал болж байна.

Хөтөлбөрийн урьдчилсан магадлан итгэмжлэлийн шалгуур (www.acsmon.mn)-т “Хөтөлбөрийн төгсгөлд оюутны эзэмшсэн байвал зохих мэдлэг, чадвар, чадамжийг заасан суралцахуйн хүрэх үр дүнгээр хөтөлбөрийн зорилтыг тодорхойлох ба энэ нь үндэсний мэргэшлийн хүрээ, сургуулийн зорилт, холбогдох мэргэжлийн салбар болон оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна” гэж заасан боловч МҮХ-г хараахан батлаагүй байна.

Хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн шалгуур (www.acsmon.mn)-т “төгсөгчийн эзэмшсэн байх мэдлэг, ур чадвар, хандлага нь мэргэжлийн салбарын хөгжил, зах зээлийн эрэлтэд нийцсэн байна” гэж заасан боловч мэргэжлийн салбар, хөдөлмөрийн зах зээлийн хүлээлт буюу суралцахуйн хүрэх үр дүнг тодорхойлоогүй байгаа нь шинжилгээ, үнэлгээ, дүгнэлтийг бодит хийх боломжгүй байна.

2017 оноос хийгдэж байгаа шинэ болон хэрэгжиж байгаа хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн өөрийн үнэлгээний тайлангуудаас үзэхэд суралцахуйн хүрэх үр дүн нь мэргэжлийн салбар, оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагад нийцсэн эсэхийг тогтоохдоо төгсөгч, ажиллогчдын төлөөллийн оролцоотойгоор хэлэлцэж байгаа нь зөв эхлэл боловч үр дүн нь

харилцан адилгүй, мөн үнэхээр нийцсэн эсэхийг үндэслэлтэйгээр харилцан хүлээн зөвшөөрсөн эсэх нь тодорхой бус байна. Эдгээр тайлангуудад шинжээчид хөндлөнгийн үнэлгээ хийж, шийдвэр гараагүй байгаа тул дүгнэлт хийхэд эрт байгаа боловч дараах асуудлуудыг яаралтай судлах шаардлагатай байна. Үүнд:

1. Суралцахуйн хүрэх үр дүн нь хөтөлбөрийн нэр, индекстэй хэрхэн уялдах вэ?
2. Ижил нэр, индекстэй өөр шатлалын хөтөлбөрүүдийн суралцахуйн үр дүнгийн ялгаа нь юу вэ?
3. Төрөлжсөн болон нарийвчилсан нэг чиглэлд хамаарах хөтөлбөрүүдийн нийтлэг суралцахуйн хүрэх үр дүн юу вэ?

Дээрх асуудлуудыг тогтоохгүйгээр хөтөлбөрийн урьдчилсан магадлан итгэмжлэлийг хэрэгжүүлж, сургалт эрхлэх тусгай зөвшөөрөл олгох нь учир дутагдалтай.

Хэрэгжиж байгаа бүх хөтөлбөрөөс өөр хэрэгцээ, шаардлага байгаа учраас ДБСБ нь шинэ хөтөлбөрийг боловсролын зах зээлд нийлүүлэхийн тулд шинэ суралцахуйн үр дүнг тодорхойлж, түүнийг хэрэгжүүлэх шинэ агуулга, багшлахуйн болон суралцахуйн арга барил, нөөц ба орчин нөхцлийг төлөвлөх ба өмнөх туршлагадаа тулгуурлан чанарын баталгаажуулалтын механизмыг сайжруулах боломжтой. ДБСБ нь урьдчилсан магадлан итгэмжлэлээр шинэ хөтөлбөрөө амжилттай хэрэгжүүлэхэд шаардлагатай зөвлөх үйлчилгээг мэргэжлийн байгууллага, мэргэжилтнүүд, бусад оролцогчдоос авч, чадавхиа бэхжүүлнэ.

Шинэ суралцахуйн үр дүн, түүнийг хэрэгжүүлэх агуулга нь шинэ хөтөлбөрийн ялгарах гол шинж бөгөөд багшлахуйн болон суралцахуйн арга барил, багшлах бүрэлдэхүүн, орчин ба нөөц, удирдлага, суралцагчийг дэмжих үйлчилгээ, суралцагчийн үнэлгээ, чанарын баталгаажуулалт зэрэгт тэрхүү ялгарах шинжийг хэрхэн тусган сайжруулж байгааг үнэлэх нь чухал юм.

Суралцахуйн үр дүн нь хөтөлбөрийн төдийгүй ДБСБ-ын үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх, сайжруулах үндсэн хэрэгсэл болсон бол суралцахуйн үр дүнд суурилсан чанарын баталгаажуулалтын тогтолцоо бүрдэнэ.

Дүгнэлт

Урьдчилсан магадлан итгэмжлэлийн 6 шалгуурын 4-т нь суралцахуйн хүрэх үр дүнг чухалчилж байгаа нь суралцахуйн үр дүн нь өөрийн болон хөндлөнгийн үнэлгээний гол хэрэгсэл болохыг харуулж байна. Нөөц ба хөтөлбөрийн удирдлага, Чанарын баталгаажуулалт гэсэн хоёр шалгуурт дурьдагдаагүй боловч төлөвлөх, үнэлэхэд суралцахуйн үр дүнг тооцох учир шууд биш ч холбоотой.

Бүх хөтөлбөрийг ижил шалгуураар урьдчилан магадлан итгэмжлэх нь төрөлжсөн, нарийвчилсан чиглэл, тодорхой хөтөлбөрийн онцлогийг үнэлэх боломжгүй байна. Тиймээс урьдчилсан магадлан итгэмжлэлийн шалгуур нь тухайн хөтөлбөрийн чанарыг хангалттай батлах эсэхийг цаашид судлан тогтоох нь зүйтэй.

Шинэ болон хэрэгжиж байгаа хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн өөрийн үнэлгээний тайланд суралцахуйн хүрэх үр дүнг тодорхойлон чухалчлах болсон нь

харагдаж байгаа боловч энэ нь өдөр тутмын үйл ажиллагаанд тууштай хэрэгжиж байгаа баримт нотолгоо хангалтгүй байна. Ихэнх хөтөлбөрүүд суралцахуйн үр дүнг магадлан итгэмжлэлийг эхлүүлэхийн өмнөхөн тодорхойлсон, гэвч сургалтын төлөвлөгөө нь хуучин зорилго, зорилт дээрээ үндэслэсэн бүтэцтэй, агуулга болон арга зүй нь үндсэндээ өөрчлөгдөөгүй хэвээр байна. Энэ нь

шинжээчид хөндлөнгийн үнэлгээ хийх, шалгуурт нийцсэн эсэхийг баримтаар нотлоход хүндрэлтэй байж болзошгүй юм.

Суралцахуйн хүрэх үр дүн ба хүрсэн үр дүнг илрүүлж, хэмжиж, үнэлж, харьцуулж болохуйцаар тодорхойлбол оролцогч талууд ялангуяа ажил олгогчдын төлөөлөл хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх, үнэлэх, сайжруулах үйл явцад оролцоход хялбар дөхөм байх нь тодорхой.

Ашигласан материал

1. (Bologna) Ministry of Science, Technology and Innovation (2005). A Framework for Qualifications of the European Higher Education Area. Copenhagen.
2. EC, ECTS Users Guide (2005, 2009, 2012).
3. OECD & UNESCO (2005). The Guidelines for Quality Provision in Cross-Border Higher Education.
4. OECD, Vincent-Lancrin, S., & Pfotenhauer, S. (2012). Guidelines for Quality Provision in Cross-Border Higher Education: Where Do We Stand?. Paris.
5. Батчимэг, Н. & Тамир, Ч. (2013). Дээд боловсролын бодлогын шинжилгээ, МУИС
6. Бат-Эрдэнэ, Р. (2012). Монголын дээд боловсролын реформ "бодлогын шийдэл, үр дагавар". Боловсролын бодлого судлал Монголд. Улаанбаатар.
7. Мөнххүж, Б. & Гантөмөр, Я. (2017). Боловсролын тухай дахин эргэцүүлэн бодох нь. Улаанбаатар: ШУТИС Хэвлэлийн газар.
8. Судирман Я. & Цагаач, Г. (2016). Дээд боловсролын мэргэшлийн үндэсний хүрээ. HERP MON Loan No. 2766 төслийн тайлан.
9. <http://www.unideusto.org/tuningeu>
10. <http://www.herp.mn>
11. <http://www.accmon.mn>

